

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР БӨГӨӨД ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т. АЛТАНХУЯГ

**Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын техникийн
нөхөн сэргээлтийн ажлын даалгавар**

2024.08.15

1. Ажлын зорилго

“Цемент Шохой ХХК” нь 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант 3-р багийн нутагт орших “Их Өлөнт” гэх газар бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ.

2. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Төслийн талбай нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт “Их Өлөнт”-ийн аманд байрших Ерөө сумын Бугант 3-р багийн төвөөс 18 км-т зүүн урагш байрлана.
- 2.2. Нөхөн сэргээх талбайн төлөв байдал нь бичил уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн ухсан нүх, овоолго болон угаах төхөөрөмжийн хаягдал болох эфель гааль тархсан талбай болно. Дээрх талбайд “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөж байна.

3. Ажил гүйцэтгэх үндэслэл

- 3.1.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.6-д заасны дагуу дүйцүүлэн хамгааллын хүрээнд тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант 3-р багийн “Их Өлөнт”-ийн аманд дүйцүүлэн хамгаалал нөхөн сэргээлт хийх;
- 3.1.2. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд тус талбайн овоолгын ханыг хэвгийжүүлэх, түрж тэгшлэх ажлууд хамаарах бөгөөд “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх” тухай 2015 оны А/138 тоот тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэнэ.
- 3.1.3. 2024 оны “Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд” тусгагдсан.

4. Хамрах хүрээ, хийгдэх ажил

- 4.1. Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх;
- 4.2. Нөхөн сэргээлт хийгдэх талбайд ажил эхлэхээс өмнө маркшейдерийн хэмжилт хийлгэх;
- 4.3. Тухайн солбицлыг цэгт өндөр-1,50 м, 80х70 харьцаатай хаягжуулалт хийх;

5. Ажлын үе шатууд

1 үе шат

- 5.1. Төслийг “Цемент Шохой ХХК”-ны мэргэжилтэнүүд техникийн дагуу тендерийн бичиг баримтыг боловсруулж, олон нийтэд зарлан хүлээн авч төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах,
- 5.2. Сонгогдсон компани, аж ахуй нэгж байгуулагатай гэрээ байгуулах,

2 үе шат

- 5.3. Календарьчилсан төлөвлөгөө боловсруулах,

6. Ажил гүйцэтгэхэд тавигдах шаардлага

6.1. Боловсон хүчин:

- 6.1.1 Дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээлтийн чиглэлээр 3 жилээс дээших хугацаанд үйл ажиллагаа явуулсан байх;
- 6.1.2 Экологич байгаль орчны мэргэжилтэй хоёр болон түүнээс дээш жилийн ажлын туршлагатай ажилтнуудтай байх;
- 6.1.3 Нөхөн сэргээлт хийх техник, тоног төхөөрөмжтэй байх;

6.2. Техникийн шаардлага:

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант 3-р багийн нутагт орших “Их Өлөнт” гэх газар бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх.

6.2.1. Техникийн нөхөн сэргээлтийн үе шатанд дараах үндсэн ажлуудыг гүйцэтгэсэн байна.

6.2.2. Овоолгын гадаргууг тэгшлэх, суваг шуудуу болон далд уурхайн ашиглалтын үед цөмөрсөн газрыг булах, тэгшлэх;

6.2.3. Нөхөн сэргээгдсэн газарт хөдөө аж ахуй болон бусад төрлийн тээврийн хэрэгсэл, техник нэвтэрч болохуйц зам тавих;

6.2.4. Ил уурхайн ёроол ба хажууг засах, үйлдвэрлэлийн явцад тогтсон ус, цөөрөм болон даланг ашиглах, эсвэл дарах, голын гольдрол, эргийг засаж тохижуулах;

6.2.5. Газрын гадаргууг үржил шимт болон шимэрхэг хөрсөөр хучих, газар нутгийг байгалийн нөлөөгөөр (нар, салхи, усны) эвдрэлд орохоос хамгаалах арга хэмжээ авах;

6.2.6. Тэгшлэн засах ажлыг хийхдээ нөхөн сэргээж буй гадаргууг хэт нягтруулахгүй байх машин техникээр хийж, газрыг сийрэгжүүлэн өвс, ургамал ургах бололцоог бүрдүүлнэ.

7. Тусгай шаардлага


7.1. Тендерт оролцогч нь тухайн ажилд шаардлагатай тусгай зөвшөөрлийг Байгаль орчин аялал жуучлалын яамнаас газрын хэвлий нөхөн сэргээлтийн ажил хийх эрх авсан, eic.mn мэдээллийн санд бүртгэлтэй байх;

7.2. Дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэж байсан туршлагатай байх;

Нөхөн сэргээлт хийх талбайн зураглал

Сэлэнгэ аймаг, Ерөө сум, Бугант баг, Их өлөнт дахь

2024 оны дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлт хийх солбицлын цэг



8. Бусад

8.1. Явцын тайлан

8.1.1. Гүйцэтгэсэн ажлын тухайн тайлан, дүгнэлт /хэвлэмэл болон цахим хэлбэрээр/ bolortuya@khutulcemen.mn гэсэн цахим шуудангаар илгээнэ.

8.1.2. Тайланд хавсаргах материал /акт, баримт, үйл ажиллагааны фото зураг, маркшейдерийн зураглалын ажил хийлгэж/ ирүүлэх;

8.2 Материал хүлээлгэн өгөх

8.2.1. Ажлын тайланг цахим хаягаар болон хэвлэмэл байдлаар Монгол хэл дээр 4 хувь хийж ирүүлэх;

8.2.2 Материалыг өгөх, хүлээж авах асуудлыг Сэлэнгэ аймгийн Байгаль Орчин аялал жуучлалын газар, Байгаль орчны мэргэжилтнүүд хариуцна.

8.3 Гүйцэтгэсэн ажил хүлээлгэн өгөх

8.3.1 Тухайн ажлыг захиалагч талаас байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хүлээлгэн өгөх;

9. Ажил гүйцэтгэх хугацаа

9.1. Ажил эхлэх

9.1.1. Ажил гүйцэтгэх хугацаа нь техникийн даалгавар батлагдсан өдрөөс шууд эхлэнэ.

9.2. I үе шат

9.2.1. 2024 оны __ сарын __-ны 2024 оны __ сарын__ өдөр хүртэл техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ.

9.2.2. 2024 оны__ сарын__ -ны дотор тайлангийн материалыг захиалагчид хүлээлгэн өгнө.

9.2.3 2024 оны__ сарын__ -ны дотор нөхөн сэргээлтийн ажлыг хүлээлгэн өгнө.

9.3. II үе шат

9.3.1 Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн техникийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг захиалагчтай хамтран орон нутагт хүлээлгэн өгснөөр тухайн ажил дуусгавар болно.

Стандарт болон кодын дүйцэх байдал:

Нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхдээ дараах сандартыг мөрдлөгө болгон ажиллана. Үүнд:

1. MNS 17.5.1.19-92: Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага;
2. MNS 5917-2008 5х: Байгаль орчин, уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийхэд тавигдах техникийн ерөнхий шаардлага.

Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй жишихүйц, эсхүл түүнээс илүү чанартай бусад стандарт, кодыг төслийн менежер хянаж, бичгээр зөвшөөрөл олгосон бол хүлээн зөвшөөрнө.

Төсөвт өртөг:

НӨАТ-тай
165.000.000 төгрөг

АЖЛЫН ДААЛГАВАР ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭЛТСИЙН

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

З. Болортуяа

З.БОЛОРТУЯА

ТӨСӨВТ ӨРТӨГ ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ БӨГӨӨД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ДАРГА

БАЙГУУЛЛАГЫН НӨӨЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА


Х.Төмөрчөдөр
Х.Батсүрэн

Х.ТӨМӨРЧӨДӨР

Х.БАТСҮРЭН



Сэлэнгэ аймаг Ерөө сум Бугант /Их өлөнт/



Масштаб 1:4,500

